



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023
ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төлөвлөгөөг хянасан:

Аймгийн засаг дарга
(албан тушаал)

/Тэмдэг/

Төлөвлөгөө тайлагнасан:

Хэлтсийн дарга
(албан тушаал)

/Тэмдэг/

Төсвийн Ерөнхийлөн захирагч

..... /А.Ишдорж/
/гарын үсэг/

Төсвийн шууд захирагч

...../Б.Цэдмаа/
/гарын үсэг/

.....
(огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хав

"ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН"

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт/хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.							
/“Алсын хараа-2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр”-ийн 3.3.4.4/							
Зорилт1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.							
1.1	Өвөрхангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын санхүүжилтийг улсын төсөвт	Улсын төсөв 2.000,0 сая.төг	Санхүүжилтийг улсын төсөвт суулгасан эсэх	Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/208 захирамжаар Арвайхээр	2023 оны улсын төсөвт санхүүжилтийг тусгуулсан байна.	Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нар нь 2023 оны 03 дугаар сарын 04-ний өдөр тус аймагт ажиллах үеэр хэлтсийн байрыг 2023 оны сайдын багцад хамруулан шинээр барихаар шийдвэрлэсэн. Аймгийн Засаг даргын	100%

	суулгах			<p>сумын 13 дугаар баг, Т.Намнансүрэ нгийн 7-р гудамж, 711 тоот хаягтай 1200 мкв газрыг 30 жилийн хугацаатайгаар газар эзэмших 0000002073 дугаартай, улсын бүртгэлийн Э1018001131 дугаарт бүртгүүлэн санхүүгийн тайланд тусгаад байна.</p>		<p>зөвлөлийн хурлаар холбогдох байгууллагуудын төлөөллийг байлцуулан 3 удаагийн хуралд барилга барих газрын байршил, газрын хэмжээг нэмэгдүүлэх хөрсний шинжилгээ хийлгэх, техникийн нөхцөлийг гаргуулах зэрэг асуудлыг хэлэлцүүлэн, барилгыг зоорийн давхар бүхий 2 давхар барилга барихаар төлөвлөн, зураг төслийг "ББСМО" компаниар гаргуулсан. Төсвийн хэмнэлтийн тухай хууль батлагдсанаар төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдуулан сайдын багцад хамруулан төсөвт тусгагдах байсан барилгын санхүүжилт батлагдаагүй. Тус хэлтсийн ашиглаж байгаа барилга нь үйл ажиллагаа явуулах боломжгүй, үйл ажиллагаагаа зогсоох тухай мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2022.11.04 өдрийн №15/02/007/129 дүгнэлтийг хүлээн авч, холбогдох шат шатны албан тушаалтнуудад хүргүүлэн аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулга бэлтгэн танилцуулсан. 2022 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, аймгийн Засаг дарга А.Ишдорж, ИТХ-ын дарга Д.Пүрэвдорж болон аймаг орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүдтэй ажлын уулзалт хийснээр одоо ашиглаж байгаа аймгийн мэргэжлийн хяналтын газрын 1200 мкв талбай бүхий барилгыг улсын бүртгэл архивын чиглэлээр ашиглуулахаар зөвшилцөлд хүрсэн.</p>
--	---------	--	--	--	--	--

1.2	Бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийг орон нутгаас шийдвэрлэх	Орон нутгийн төсөв	Шинэчилсэн тоног төхөөрөмжийн тоо	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын тоног төхөөрөмжүүд элэгдсэн, ашиглалтын хугацаа дууссан.	2-4 бүртгэгчийн компьютер тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулсан байна.	Арвайхээр сумын Засаг дарга Б.Ганбатад 2022.04.01-ний өдрийн 215 дугаар албан бичиг, 2022.08.25-ны өдрийн 525 дугаар албан бичгээр аймгийн Засаг дарга А.Ишдорж нарт тус тус шаардлагатай тоног төхөөрөмж хүссэн саналыг хүргүүлснээр аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс төлбөр тооцооны Гэрэгэ Киоск машиныг 3,500.0 мянган төгрөг, улсын бүртгэлийн бүртгэл лавлагааны цахим машины үндсэн үнийн дүнгийн 50% болох 11,900.0 мянган төгрөгийг шийдвэрлүүлсэн. Бүртгэлий хэлтэст Санон 3010 принтер 1ш-725000, 4G төхөөрөмж 1ш- 1228700, HP-DS 70000 scanner-1ш, hp-DS 1060 1ш тус тус шийдвэрлүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100%
1.3	Одоо үйл ажиллагаа явуулж байгаа хэлтсийн байрны өнгө үзэмжийг сайжруулж тодорхой хэсгийг засварлах.	Орон нутгийн төсөв 20.0 сая төгрөг	Засвар үйлчилгээ хийгдсэн эсэх;	Хэлтсийн байр нь ашиглалтын шаардлага хангахгүй иргэдэд үйлчилгээ үзүүлэх боломжгүй талаарх мэргэжлийн байгууллагын 2 удаагийн дүгнэлт гарсан.	Байрны засвар үйлчилгээг хийсэн байна.	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,395,000 төгрөгийг гаргуулж хэлтсийн 1 өрөө, байгууллагын урсгал санхүүжилтээс 2 өрөөг засварлаж, үйлчилгээний зааланд байрлах самбар, гэрэлтүүлгийг шинээр хийж, гадна хаягийг монгол бичгээр шинэчлэн нийт 771,950 төгрөгийг зарцуулсан.	100%

1.4	Улсын бүртгэлийн байгууллагын харьяа нэгжүүдэд цахим төлбөрийн хэрэгсэл болох пос машины тоог нэмэгдүүлэх.	Төрийн болон төрийн бус байгууллагын тусламж, дэмжлэг	Пос машинаар үзүүлсэн үйлчилгээний тоо.	-	Пос машин байршуулсан байна. -Үйлчилгээний хураамжийг цахим төлбөрийн хэрэгсэл ашиглах боломж бүрдсэн байна.	2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Өвөрхангай аймгийн Засаг дарга А.Ишдоржийн дэмжлэгээр 3,500,000 /гурван сая таван зуу мянга/ төгрөгийн үнэ бүхий төлбөр тооцооны ГЭРЭГЭ КИОСК машиныг хэлтсийн үйлчилгээний зааланд байршуулан улсын бүртгэлийн үйлчилгээний төлбөрийн дансуудыг холбож, үйлчилгээнд нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн аймгийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйлчилгээний зааланд суурилуулан дансны холболтыг хийж, иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэв. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсийг гэрэгэ киоск машинаар нийт 22040 иргэн, үйлчилгээний хөлсөө төлж, улсын төсөвт нийт 105,250,000 /сая/ төгрөгийн орлого төвлөрүүлэн ажиллав.	100%
1.5	Улсын бүртгэлийн зарим үйлчилгээг	Төрийн болон төрийн бус байгууллагын	Байршуулсан киоск машины тоо.	-	Иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан	2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан	100%

	цахим машинаар үзүүлэх. /Киоск/	тусламж, дэмжлэг			байна.	нар тус аймагт ажиллах үеэр 23,800,000 төгрөгийн өртөг бүхий цахим машиныг байрлуулсан. Дээрх цахим машиныг ашиглаж эхлэснээр иргэний бүртгэлийн бүх төрлийн лавлагаа, гадаад паспортын зургийг илгээх боломтой болсон мөн тоон гарын үсгийг иргэний үнэмлэх болон гар утсанд олгодог болсноор иргэд цаг алдалгүй өөрөө өөртөө үйлчлэх боломжоор хангагдсан байна. ирэх онд цахим машины програмын сайжруулалт хийгдсэнээр улсын бүртгэлийн 3 төрлийн бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг цахим машинаас авах боломжтой болно. 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр аймгийн Засаг даргын дэмжлэгээр үйлчилгээний зааланд киоск машиныг суурилуулсан. Дээрх төлбөрийн киоск машиныг хэрэглээнд нэвтрүүлснээр иргэд банк явж цаг алдалгүй үйлчилгээгээ түргэн шуурхай авах боломжоор хангагдсан.	
--	---------------------------------------	---------------------	--	--	--------	--	--

Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.

2.1	E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг сурталчлах, аймгийн хэмжээнд үзүүлсэн цахим бүртгэлийг нэмэгдүүлэх.	-	-Цахим хэлбэрээр үзүүлсэн үйлчилгээний төрөл	-	<p>-Төрийн үйлчилгээний нэгдсэн портал E-mongolia-аар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний тоог нэмэгдүүлсэн байна.</p> <p>-Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цахим хэлбэрээр бүртгэсэн байна.</p> <p>-Төрсний, гэрлэсний гэрчилгээ дахин олгох үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэсэн байна.</p> <p>-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн өмчлөх эрхийг анх удаа бүртгэх /6/, өмчлөх эрхийн шилжилт /10/, нэмэлт өөрчлөлт болон бусад эрхийн бүртгэл /20/ нийт 36 төрлийн бүртгэлийг цахим хэлбэрээр бүртгэсэн байна.</p> <p>-Шинээр болон өөрчлөн байгуулагдсан хуулийн этгээд /13 хэлбэр/-ийн, мэдээлэлд оруулсан өөрчлөлт /5 мэдээлэл/-ийн бүртгэлийг цахим хэлбэрээр бүртгэсэн байна.</p>	<p>Төрийн үйлчилгээний нэгдсэн портал E-mongolia-аар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг байгууллагын цахим хаяг, фэйсбүүк хаяг, орон нутгийн телевиз, мэдээ, шторк хэлбэрээр иргэдэд сурталчилсан. Тайланд хугацаанд E-mongolia системээр гадаад паспортын бүртгэл 45, иргэний үнэмлэх 67, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл 3, нийт 115 бүртгэлийг хийлгэж, иргэдэд шуурхай хүргүүлсэн. Үйлчилгээний зааланд байршуулсан "Цахим туслагч" булангийн зөөврийн компьютераар "E-Mongolia" системээр дамжуулан эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 1157 иргэнд банк болон банк бус санхүүгийн байгууллагын зээлийн дараах болон бусад лавлагааг, иргэний бүртгэлээр 2527 иргэнд лавлагааг олгож ажиллалаа. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн "Төрийн үйлчилгээний хүсэлтийг бүртгэх хяналтын систем"/servive.e-mongolia/-д илгээсэн 896 иргэний хүсэлтийг хүлээн авч боловсруулан зохих журмын дагуу шийдвэрлэсэн. Үүнд: Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах хүсэлт 855, шинээр хуулийн этгээд байгуулах хүсэлт 6, хуулийн этгээдийн цахим гэрчилгээ олгох хүсэлт 35 байна.</p>	100%
-----	--	---	--	---	--	---	------

--	--	--	--	--	--	--	--

	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийг хэрэглээнд нэвтрүүлэх.	-	-Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо; -Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо	-	-Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэсэнээр иргэн, хуулийн этгээд, банк санхүүгийн байгууллагад хүргэх төрийн үйлчилгээ түргэн шуурхай, хялбар болсон байна.	Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд барьцааны гэрээ, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, барьцааны гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг хөнгөн шуурхай, хялбар болгох ажлын хүрээнд УБЕГазрын даргын 2022 оны А/427 дугаар тушаалаар "Барьцааны гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ6/, барьцааны гэрээний нэмэлт өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-13/маягт батлагдсан маягтуудыг барьцаалагч хуулийн этгээд, иргэнээр хөтлүүлэн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд албан бичгийг холбогдох мэдээллийн хамт арилжааны банк-4, банк бус санхүүгийн байгууллага-8, хадгаламж зээлийн хоршоо-1,2 иргэнд сургалт зохион байгуулж мэдээллээр хангаж ажиллав.Тайлант хугацаанд нийт ЭУБ-06 маягтаар 3,339 барьцааны гэрээ, ЭУБ-13 маягтаар 373 барьцааны гэрээний нэмэлт өөрчлөлтийг тус тус бүртгэсэн.	100%
2.3	Улсын бүртгэлийн архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийг нэгдсэн санд цахим хэлбэрээр хөтлөх	-	-Цахим санг үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлсэн эсэх; -Цахим санд оруулсан архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийн тоо.	-ХЗДХС-ын 2020 оны А/241 дугаар тушаалаар баталсан "Үндэсний архивын сан хөмрөгийн баримтын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх	-Архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтөлсөн байна.	Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газраас ирүүлсэн 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10/802 дугаар чиглэлийн дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд цахим мэдээллийн санд эцэг, эхийн мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн, мэдээлэл байхгүй 2004-2011 оны 211 иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж, 191 иргэний 480 нүүр, ИУБ /ХААТр/ 11, 12, 13, 14, 25, 31	100%

				<p>журам"-ын дагуу хөмрөг үүсгэгчийн бүрэлдэхүүн, баримтын тоо хэмжээ, хадгалалтын мэдээллийг гарган АЕГ-ын нэгдсэн тоо бүртгэлийн системд тусган ажиллаж байна.</p>		<p>маягтуудыг цахимжуулан баталгаажуулсан. Улсын бүртгэлийн нэгдсэн архивын цахимжуулсан материал харах, ашиглах, засварлах, програмыг 2022 оны 03 сараас эхлэн цахим мэдээллийн санд зөрүүтэй цахимжаагүй хувийн хэрэг болон эх нотлох баримтыг цахимжуулахаар иргэний улсын ахлах бүртгэгчид програмд ажиллах эрхийг нээсэн. Програмд ИУБ/ХААТр/11-91ш, ИУБ/ХААТр/12-7ш, ИУБ/ХААТр/13-15ш, ИУБ 31-23ш хяналтын улсын байцаагчийн дүгнэлт 83 нийт 219 баримтыг тус тус цахимжуулан ажиллалаа. Баримт бичиг нягтлан шалгах комиссын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг баталж, архивт шилжүүлсэн баримтад үндэслэж, байгууллагын архивын байнга, түр хадгалагдах баримтын данс бүртгэлийг үйлдсэн. Одоогийн байдлаар байгууллагын архивт байнга хадгалах 69, түр хадгалах 635 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Байгууллагын архивын баримтыг цаасан сууриар болон able програмаар хөтөлж байгаагаас Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын болон хэлтсийн даргын А, Б 253 хуудас тушаалыг able программын тушаал, шийдвэр хэсэгт бүртгээд байна.</p>
--	--	--	--	--	--	---

2.4	Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг эхлүүлэх	-	-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумдын тоо; -Сумын улсын бүртгэгчийн хөтөлсөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоо.	-3 сумын улсын бүртгэгч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн эрх авч, улсын бүртгэл хөтлөх сургалтад хамрагдаж эхэлсэн.	-Сумдад бүртгэх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эрх олгох шалгалтад шаардлага хангасан 8 эрхзүйч шалгалтад хамрагдсанаас Богд, Есөнзүйл, Сант, Хархорин сумын улсын бүртгэгчид EPRS2 программын эрх олгогдсон. EPRS2 программын эрх олгогдсон сумдыг 2022 оны 02 дугаар сарын 11-18-ны өдрүүдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт 7 хоногийн дадлагжуулах сургалтанд хамруулсан. Дээрх сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг түргэн шуурхай хүргэснээр сумын иргэд, аймгийн төв явахгүйгээр эд хөрөнгийн эрхийн бүх төрлийн үйлчилгээг тухайн сумын улсын бүртгэгчээс түргэн шуурхай авах нөхцөл бүрдүүлсэн.Тайлант хугацаанд Богд сумын улсын бүртгэгч 128 мэдүүлэг, Сант сумын улсын бүртгэгч 58 мэдүүлэг ,Есөнзүйл сумын улсын бүртгэгч 57 мэдүүлэг тус бүр хүлээн авч цахим мэдээллийн санд боловсруулалт хийж, цаасан суурьт эх нотлох баримтыг архивт хүлээлгэн өгсөн.	100%
-----	--	---	--	--	---	--	------

2.5	Архивын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах	-	-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо; - Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	-21 аймагт болсон бүсчилсэн сургалтад оролцож, сургалт, мэдээлэл хүргэсэн. -Төрийн архивын улсын үзлэгийг дүгнэх аргачлалын дагуу гүйцэтгэлийн биелэлтийг авч дүгнэсэн.	-Архивын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хангагдсан байна.	Иргэний улсын бүртгэлийн архивын, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр 8 заалт бүхий авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нас баралтын 30643 ХААТР /ИУБ/ маягтуудыг эмхлэн цэгцэлж он цагийн дараалалд оруулан хайрцагласан. Иргэний баримтын архивын хүүхдийн санд хадгалагдаж байгаа 1997-2006 онд төрсөн 3267 иргэдийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд шалгаж, тодорхойгүй төлөвтэй 460, хүчингүй төлөвтэй 22, нас барсан 182, регистрийн дугаар тодорхойгүй 11, регистрийн дугаар давхардсан 8 шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 334, шилжсэн 2256 иргэний хувийн хэргийн ангилж, алдаатай бүртгэлийн зөрчлийг арилгах, нас барсан иргэдийн маягыг нас барсны бүртгэлийн санд байршуулж, шилжин явсан иргэдийн хувийн хэргийг оршин суугаа хаягийн дагуу хүргүүлсэн. Эд хөрөнгийн архив нь Өвөрхангай аймгийн 19 сумын ЭХЭБ-ийн эх нотлох баримтын 3000 гаруй хувийн хэрэг хавтас хуучирч муудсан сэргээн сэлбэн шинээр шинэчилэн хавтасласан. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэлд өөрчилт оруулсан 173 хувийн хэргийг шинээр хавталсан баяжилт хийн байршуулаад байна. Хуулийн этгээдийн шинээр бүртгэл хийгдсэн 166 хувийн хэргийг улсын бүртгэлийн дугаарлалтын дараалалын дагуу нэгж үүсгэсэн. Эд хөрөнгийн эрхийн тасгийн хэмжээнд одоогийн байдлаар газар өмчлөх 16797, Газраас бусад үл хөдлөх эд	85%
-----	--	---	---	--	--	---	-----

					<p>хөрөнгө 13064, Эзэмших 4855, хөдлөх хөрөнгө 5, нийт 34928 хувийн хэрэг бүрдлийн эх нотлох баримт бичиг халгалагдаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар газрын 594, үл хөдлөх эд хөрөнгийн 382 нийт 977 хувийн хэрэг шинээр нээгдсэн байна. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 6/3763 тоот чиглэлийн дагуу архивт хадгалагдаж байгаа цаасан эх нотлох баримтуудыг цахим мэдээллийн сантай нэг бүрчлэн тулган тоолох, цэгцлэх ажлыг Эд хөрөнгийн бүртгэлийн архив, хуулийн этгээдийн архив тооллого хийх удирдамжийн дагуу 2022 оны 05 дүгээр сарын 01-наас 2022 оны 06 сарын 25-ны өдрийг дуустал хугацаанд нийт 19 сумын 34928 хувийн хэрэг, хуулийн этгээдийн 1928 хувийн хэргийг дугаарлалт болон баяжуулалтыг цахим мэдээллийн сантай тулган тоолсон. Мөн Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн хувийн хэргийн элдэгдэж муудсан , дугаарлалт арилсан 1200 хавтасуудыг шинэчлэн сэлбэн засварласан. Архивт багтаамж хүрэлцэхгүй болсоноос хувийн хэрэг байршуулах боломжгүй байсан бөгөөд Хэлтсийн даргад уламжлалж хэлсний үндсэн дээр үйлчилгээний заалны талбайнаас 15 мкв-ийг багасган эд хөрөнгийн архивын зориулалтаар засварлан өгч эд хөрөнгийн 3000 ширхэг хувийн хэрэг, хуулийн этгээдийн 500 хувийн хэрэг багтах тавиур угсарч суурьлуулж , цаасан суурь бүхий хувийн хэрэг багтаан суурьлуулж баяжуулалт хийж байршуулаад байна.</p>	
--	--	--	--	--	---	--

2.6	Аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэст хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах.	-	- Цахимжуулсан иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтын тоо	-Иргэний улсын бүртгэлийн онлайн, офлайн системийн хөгжүүлэлтээр иргэний улсын бүртгэл хөтөлсөн эх нотлох баримт бичгийг цахимжуулах боломжийг бүрдүүлэх.	-Эх нотлох баримтын бүрдүүлбэрийг тухай бүр цахимжуулсан байна.	Тайлангийн хугацаанд 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/134 дугаар чиглэлийн дагуу 15061 бүртгэлийн 35352 хуудас бүхий эх нотлох баримт бичгийг цахимжуулаад байна. Эх нотлох баримтыг тухай бүрт нь цахимжуулж, баталгаажуулах шатанд нь хяналт тавин ажиллаж байна.	100%
-----	---	---	--	---	---	--	------

2.7	<p>Нотариатчтай “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулах, дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл нийлүүлэх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд нотариатч зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх.</p>	-	<p>-Дундын мэдээллийн сангаар дамжуулан нотариатын мэдээлэл шалгах системд нийлүүлсэн мэдээллийн тоо; -Нотариатаар зуучлуулан эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн бүртгэлийн тоо.</p>	<p>-2021 онд нийслэл, орон нутгийн 218 нотариатчтай гэрээ байгуулж, системд нэвтрэх эрх олгосон. -Монголын Нотариатын танхимын сургалтад танилцуулга, мэдээлэл хийсэн. Нотариатчийн зуучлах модуль, системийн үйл ажиллагааны талаар Монголын нотариатын танхим, “Интерактив” ХХК-тай хамтарсан уулзалтуудыг хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудлаар санал солилцсон.</p>	<p>- Дундын мэдээллийн сангаар дамжуулан нотариатын нийлүүлсэн мэдээллийг тухай бүр шалгаж, бүртгэсэн байна. Нотариатчаар зуучлуулан ЭХЭУБ хөтөлсөн байна.</p>	<p>Дундын мэдээллийн сангаар дамжуулан нотариатын мэдээлэл шалгах системд хандаж нотариатын нийлүүлсэн мэдээллийг тухай бүр нь авч бүртгэл мэдээллийг бүртгэлтэй тулган нягталж 6 бүртгэлийг бүртгэсэн төлөвт шилжүүлж, материалыг хүлээн авч бүртгэж баталгаажуулсан.</p>	100%
-----	--	---	---	---	--	--	------

2.8	Тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах	-	<p>-Тоон гарын үсэг олгох бэлтгэл ажлыг хангасан эсэх;</p> <p>-Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо;</p> <p>-Иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо.</p>	<p>-Тоон гарын үсгийн тухай хууль батлагдаж, эрх зүйн орчин бүрдсэн.</p> <p>-Тоон гарын үсгийг улсын бүртгэлийн байгууллагаа с олгохтой холбоотой Тоон гарын үсгийн тухай хууль, түүнийг дагалдан гарах хуулийн төсөл, одоогийн дагаж мөрдөж байгаа хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан.</p>	<p>-Тухайн онд тоон гарын үсэг авбал зохих иргэдийн 30 хувьд нь олгосон байна.</p>	<p>Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийг иргэний хүсэлтээр, оршин суугаа газрын харьяалал харгалзахгүйгээр иргэний үнэмлэхийн санах ой буюу чипэнд, 2022 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн гар утасны аппликейшнээр дамжуулан иргэдэд олгож байна. Төрийн албан хаагчдад тоон гарын үсэг олгох ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу 5 ажлын хэсэг гарган орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран сурталчилж багийн өдөрлөг, нээлттэй хаалганы өдрүүдийг зохион байгуулан ажиллаж 196 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн 15000 гаруй албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгуулан ажилласан. Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг олговол зохих 75,825 иргэнээс 23729 иргэнд буюу 31,3 хувьд тоон гарын үсэг олгосон.</p>	100%
-----	--	---	--	--	--	---	------

Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.							
3.1	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих.	-	-Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь.	-2021 оны жилийн эцсийн байдлаар хэлтсийн шилэн дансны мэдээлэл байршуулалт 100 хувиар дүгнэгдсэн.	-Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, байршуулах ёстой мэдээллийг хугацаандаа үнэн зөв, бүрэн байршуулсан байна; - Байршуулсан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн, зөв байршуулсан ажилласан байна; -Тайланг улирал тутам, хугацаанд нь УБЕГазарт хүргүүлсэн байна.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд онцгой анхаарч хэлтсийн хэмжээнд хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулж тус хугацаанд 130 мэдээ байршуулахаас 130 мэдээ байршуулсан. Хугацаа хоцорсон дутуу байршигдсан мэдээлэл байхгүй хуулийн хэрэгжилт 100 хувьтай байна. Тухай бүрийн мэдээнд тайлант хугацаанд өссөн дүнгээр 612,103,300 төгрөгийн урсгал санхүүжилт, 187,743,325 төгрөгийн үйлчилгээний орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зарлагын гүйлгээ зэргийг хуулийн хугацаанд байршуулан ажилласан. Хэлтсийн даргын тушаал шийдвэрийг бүрэн байршуулсан. Өмнөх оны аудитын тайлан дүгнэлт, санхүүгийн жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд байршуулсан. Тус онд байгууллагын бүтэц орон тоонд төрийн захиргааны 3 албан хаагч хүүхдээ асрах жирэмсний чөлөө авсан. Бүтэц орон тооны өөрчлөлтийн хөдөлгөөнийг тухай бүрийн мэдээнд тусган ажилласан.	100%
3.2	Улсын бүртгэлийн байгууллагын байрны ашиглалт, үнэт цаас, маягт, бараа материалын хангалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулах	-	-Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг цаг тухайд хийсэн болон ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх; -Үнэт цаас, маягт болон	-2021 онд төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй, нээлттэй байдлаар хууль тогтоомжийн дагуу зарцуулсан.	-Хагас жилээр эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өмнө байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах талаар байгууллагын өмч хамгаалах байнгын	Тайлангийн хугацаанд төсвийн хөрөнгийг зүй зохистой, нээлттэй байдлаар хууль тогтоомжийн дагуу үргүй зардал гаргахгүй хэмнэлттэй байдлаар зарцуулсан. Тус хэлтэс нь 2022 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/04 тоот тушаалаар "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийг шинэчлэн байгуулсан мөн 02 дугаар 02-ны өдрийн А/05 тоот хэлтсийн даргын тушаалаар "Дотоод хяналт, шалгалтын баг" томилж, ажлын хэсэг байгуулан төлөвлөгөөний дагуу	100%

	<p>зарцуулах, тайлагнах</p>		<p>бусад бараа материал, жижиг эд хогшлын хангалтыг тасалдуулаагүй эсэх; -Байгууллагын үнэт цаас, маягт болон бусад бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан болон батлагдсан төсөв хэмнэсэн эсэх;</p>		<p>зөвлөлийн шийдвэр гаргуулж, УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлсэн байна.</p>	<p>үйлчилгээний үнэ хураамж, үнэт цаас зарцуулалт, тайлагналт, үндсэн хөрөнгө болон бараа материалын хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна. Төсвийн хүрээний 2 дугаар улиралд дээд шатны байгууллагаас 23,870,000 төгрөгийн өртөг бүхий сүүлийн үеийн технологийн дэвшилтэд Киоск машины үнэ төлбөргүй хөрөнгө оруулалт хийгдсэнийг иргэдэд үйлчлэх бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Хэлтсийн даргын тушаалаар үндсэн хөрөнгө, үнэт цаас, бараа материалын тооллогын комисс томилж хагас, бүтэн жилээр хөрөнгийн тооллог хуулийн хугацаанд хийгдэж, 136 ширхэг хүчингүй болсон үнэт цаас устгуулахаар ББНШК-т санал оруулсан. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 09 дүгээр тогтоолын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогоор шалгагдаж 98%-тай дүгнэгдсэн.</p>	
--	---------------------------------	--	--	--	---	--	--

3.3	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах.	Урсгал төсөв /516.9 сая төгрөг/	Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо.	2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авч, 2021 онд 539 сая төгрөгийн урсгал төсвөөс зарцуулсан.	Санхүү, төсвийн удирдлага, төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон тайланг хуульд заасан хугацаанд нь дээд газарт хүргүүлсэн байна; Санхүүгийн тайланг аудитын байгууллагаар хянуулсан байна; Санхүүгийн сахилга, батыг хангах, өр төлбөр, зөрчилгүй ажилласан байна.	Төсөвт байгууллагын санхүүгийн нэгдсэн тайланг 4 удаа улирлаар, төсвийн гүйцэтгэлийн мэдээг 12 удаа сараар гаргаж, улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүү аж ахуйн хэлтэст хугацаанд нь хүргэсэн байна. Мөн улсын төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулан өр төлбөр үүсгэхгүйгээр санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж, жилийн эцсийн байдлаар тэвчиж болох зардлыг хэмнэн 0 төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна. 2021 оны санхүүгийн тайланд төрийн аудитаас зөрчилгүй дүгнэлт авч, 2 зөвлөмжийн дагуу биелэлтийг ханган ажиллаж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлсэн.	100%
-----	--	---------------------------------	--	--	--	--	------

3.4	Хоршооны шинэчилсэн бүртгэлийг Хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/, улсын бүртгэлийн хууль тогтоомжтой нийцүүлэн Жижиг, дунд үйлдвэрийн газартай хамтран	-	Шинэчилсэн бүртгэлд хамрагдсан хоршооны тоо.	-	Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй байгаа хоршоог шинэчилсэн бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулсан байна.	Шинэчилсэн бүртгэлд хамрагдахаар хүсэлт гаргасан хоршооны бүртгэлийг тухай бүр нь хууль, журмын дагуу бүртгэж жилийн эцсийн байдлаар 56 хоршооны хүсэлтийг хүлээн авч бүртгэлд хамруулаад байна. Жижиг дунд үйлдвэрийн газар, хоршоологчдын холбоотой хамтран тус бүртгэлийг хуулийн хугацаанд бүртгэлд хамруулах талаар хамтран ажиллаж байгаа бөгөөд орон нутгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт тус засаг захиргааны нэгжид бүртгэлтэй 208 хоршооны судалгааг гарган хүргүүлэн ажилласан болно. Бүртгэлд хамрагдах хоршооны судалгаа гарган холбогдох иргэдтэй	100%
-----	--	---	--	---	---	---	------

	<p>зохион байгуулах.</p>					<p>утсаар болон орон нутгийн бүртгэгч нараар дамжуулан мэдээллийг хүргэсэн. Мөн 09 дүгээр сарын 28-ны өдөр "Түмний буян далай хоршоо"-ны үзүүлэх сургалтын үеэр хоршооны бүртгэл, дүрмийн өөрчлөлтийг хийлгүүлэх талаар 129 гишүүд/хоршооны гишүүд болон сумдын жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн/-д сургалтыг хүргэн ажиллалаа. Хоршооны шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгааг гарган сумдын улсын бүртгэгч нарт хүргүүлэн тухайн хуулийн этгээдтэй холбогдон бүртгэлд хамруулах талаар мэдээлэл гарын авлага хүргэн ажилласан. Нийт 19 сумын бүртгэгч нарт холбогдох мэдээллийг хүргүүлж Арвайхээр сумын 13 багийн Иргэдийн нийтийн хуралд оролцон сургалт сурталчилгаа хийж ажиллалаа. Хоршооны шинэчилсэн дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх ажлын хүрээнд хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч бүртгэл хийх явцад тухайн хуулийн этгээдийн гишүүдийн мэдээлэл зөрүүтэй, нотлох баримт байхгүй боловч программд иргэний регистрийг шивж оруулсан гишүүдийн тоо зөрүүтэй бүртгэл хүсэлтийн дийлэнх олонхийг эзэлж хүндрэлтэй байгаа болно. Хяналтын улсын байцаагчийн 2022 оны 3053, 3057 тоот дүгнэлтээр "Баянцацрал хайрхан хоршоо"3557162, "Бадамжуннай хоршоо" 3550052-ны гишүүдийн зөрүүтэй байдлыг арилгуулан шийдвэрлэсэн.</p>	
--	------------------------------	--	--	--	--	---	--

3.5	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх.	-	Зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн тоо; Зөрчлийг зөрчлийн хэрэг нээн шалган шийдвэрлэсэн тоо. Зөрчлийг зөрчлийн хэрэг нээн шалган шийдвэрлэсэн тоо.	-86 хуулийн этгээд, 8 хүний зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж 44.180.000 төгрөгийн торгуулийг оногдуулсан. -Хуулийн этгээдийн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалган, үйлдсэн зөрчлийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллага шалгаж байгаа нь баримтаар нотлогдсон 9 хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж,	-Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.20-д харьяалуулсан зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчил шалган шийдвэрлэсэн хэрэг, материалыг хуульд заасан хугацаанд /нэн даруй/ холбогдох прокурорт хянуулан, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зөрчил шалган шийдвэрлэх харъяаллын дагуу мөн хуулийн 6.10 дахь хэсэгт улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, журамд нийцүүлэн шалган шийдвэрлэж байна.Жилийн эцсийн байдлаар дээрх хууль тогтоомжийг зөрчсөн нийт 273 хүн хуулийн этгээдийн гаргасан зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 5.460.000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтыг зөрсөн 3 хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтанд зөрчлийн хэрэг нээж Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.12 дугаар зүйлийн 1-д заасан үндэслэлээр шийтгэлээс чөлөөлж шийдвэрлэсэн Хуулийн этгээдийн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалган, үйлдсэн зөрчлийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллага шалгаж байгаа нь баримтаар нотлогдсон 2 хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, хэрэгсэхгүй болгосон.	100%
-----	---	---	---	--	---	--	------

				хэрэгсэхгүй болгосон. Мөн 4 хуулийн этгээдийн зөрчилд зөрчлийн хэрэг нээж шалган шийдвэрлэсэн.			
3.6	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлан хэрэгжүүлж ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	-2021 онд зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд 16 арга хэмжээ төлөвлөн, 100 хувь биелүүлсэн.	-Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Тус хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 4 заалт, 13 дэд заалт бүхий хяналт шалгалтын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсны дагуу багуудын ажлын алба, сумын улсын бүртгэгч нартай хамтарч иргэний үнэмлэхний зөрчлийг арилгуулахаар 25, 45 насны сунгалтын бүртгэл хийлгэх иргэдийн судалгааг гаргуулан авч хяналтын улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа. 2022 оны 03 дугаар сарын 18, 04 дүгээр сарын 12-ны өдрүүдэд "Бүртгэлийн элч" нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, Арвайхээр сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 6 сургуулийн 2005, 2006 оны 16 нас хүрсэн иргэний үнэмлэх	100%

					<p>аваагүй сурагчдын судалгааг сургуулийн захиргаатай хамтран гаргаж, мэдээллийн санд тулгалт хийж, мэдээлэл нь зөрчилтэй 51 хүүхдийн зөрчлийг засварлан,иргэнийн шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 239 хүүхдийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулж, иргэний үнэмлэхжүүлсэн. Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тасгийн дарга Д.Болор-Эрдэнэтэй хамтран 09 дүгээр сарын 08-ны өдөр "Шинэ бүртгэгч- Шинэ ажлын байр" сэдэвт онлайн болон тахимын сургалтанд 8 бүртгэгчийг хамруулан эд хөрөнгийн бүртгэлийг бүртгэх явцад гарч буй нийтлэг зөрчлийг танилцуулан алдаа дутагдалгүй ажиллах талаар мэргэжил аргазүйн зөвөлгөө өгч сургалт зохион байгуулсан. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн цагдаагийн газрын эдийн засгийн ахлах мөрдөгч ахмад Н.Ул-Олдохтой хамтран улсын бүртгэгч нарт" Итгэвэл шалгая аяны хүрээнд "Авлига-гэмт хэрэг-төрийн захиргааны албан хаагчийн ес зүй" сэдвээр 4 цагийн сургалт орж авлигын эсрэг хамтдаа аянд нэгдэж алба хаагчдад батламж гардуулсан. Аймгийн тагнуулын газрын мэргэжилтэн Ч.Ууганбаяртай хамтран алба хаагчдад "Төрийн нууц Албаны нууцын тухай хууль тогтоомж, мэдээллийн сангийн аюулгүй байдал" сургалт зохион байгуулсан.</p>	
--	--	--	--	--	--	--

3.7	Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжүүлж ажиллах	-	- Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2021 онд төлөвлөгөөт 1 хяналт шалгалт хийж, 4 дүгнэлт гаргасан.	Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Тайлангийн хугацаанд бүртгэлийн хяналтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төлөвлөгөөт шалгалтыг 10 удаа, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 3 хяналт шалгалт хийж ажиллалаа. 2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсны дагуу Богд, Есөнзүйл, Нарийнтээл, Сант, Уянга, Хайрхандулаан, Сант, Бат-Өлзий, Баян-Өндөр, Арвайхээр сумдын иргэний анхан шатны бүртгэл болон түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих, бүртгэлийн үйл ажиллагаанд гарч буй зөрчлийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор төлөвлөгөөт шалгалтыг зохион байгуулж нийт 1097 бүртгэл хамрагдснаас 32 зөрчил илэрснийг хяналтын улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн хугацаатай үүрэг өгч арилган бүртгэлийн зөрчилгүй болгоод байна. Хяналт тавьсан бүртгэлийн нийт тоо 7712 Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2434, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 2244, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 279, архивын чиглэлээр 2755 бүртгэл шалгаж нийт 200 зөрчил илрүүлэн, хэлтсийн даргад илтгэх хуудсаар танилцуулж, зөрчлийн тэмдэглэл болон илтгэх хуудсыг улсын бүртгэгчдэд хүргүүлж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллав. Бүртгэлийн зөрчлийг арилгахаар иргэд болон	100%
-----	---	---	------------------------------------	---	---	--	------

						улсын бүртгэгчдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт, тайлбарын дагуу иргэний улсын бүртгэлтэй холбоотой 78, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой 4, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 56 нийт 138 дүгнэлтийг боловсруулан батлуулж 200 зөрчлийг арилгасан. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэсэн.	
3.8	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	-Улсын бүртгэлд бүртгэсэн бүртгэлийн тоо;	-Иргэний бүртгэлээр 19788, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлээр 14616, Хуулийн этгээдийн улсын бүртгэлээр нийт 1765/ers.gasr.mn-ээр 869, /servive.e-mongolia-аар 896 хүсэлт/	-Улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд хүртээмжтэй хүрсэн байна.	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр тайлангийн хугацаанд нийт 22221 бүртгэлийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу бүртгэж, баталгаажуулаад байна. Үүнд төрөлт 1819, гэрлэлт 370, цуцлалт 84, эцэг тогтоолт 75, ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний 81, үрчилсний 44, нас барсны 621, иргэний үнэмлэхийн дахин олголт 702, хугацааны сунгалт 2437, шинэ нийт 1609, үндэсний энгийн гадаад паспорт 847, шилжилт хөдөлгөөний бүртгэл 4824, бүртгэл хийж баталгаажуулсан. Тайланд хугацаанд 6255 лавлагаа олгосноос хууль хяналтын байгууллагад албан бичгээр 405, Албан хэрэгцээнд 55, иргэнд 5791 лавлагаа олгосон байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 869 бүртгэл хүлээн авсан. Үүнд: Шинэ бүртгэл 116, шинэчилсэн бүртгэл 1, мэдээлэлд өөрчлөлт оруулсан бүртгэл 523, салбар төлөөлөгчийн газрын бүртгэл 17, шилжилт хөдөлгөөн 20/шилжин ирсэн-8, явсан-12/ , татан буугдсан 7, татан буух хүсэлтээ өгсөн 21, шинэ оноосон нэрийн хүсэлт 173, оноосон нэр	100%

					<p>өөрчилсөн 10, хэлбэр өөрчилсөн 164, дахин гэрчилгээ олгосон 205, тамга тэмдгийн хяналтын дугаар олгосон 199, тамга тэмдэг хураан авсан 48, эцсийн өмчлөгч нөхөн бүртгэсэн 413, лавлагаа хуулбар 135 олгон ажилласан байна. 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн "Төрийн үйлчилгээний хүсэлтийг бүртгэх хяналтын систем"/servive.e-mongolia/-д илгээсэн 896 иргэний хүсэлтийг хүлээн авч боловсруулан зохих журмын дагуу шийдвэрлэсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-11,414 цахим суурьт бүртгэл хийж баталгаажуулсан байна. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу нийт 11,906 хувийн хэрэг бүртгэж, шалгалт хийж 1,080 бүртгэлийн зөрчлийг цахим санд ,засварлаж, зөрчилгүй болгосон.</p>	
--	--	--	--	--	---	--

3.9	Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх "Нээлттэй хаалга"-ны өдөрлөг зохион байгуулах	-	"Нээлттэй хаалга"-ны өдөрлөг зохион байгуулсан тоо;	2021 онд "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг 6 удаа зохион байгуулсан.	Нээлттэй хаалганы өдөрлөгийг 6-с доошгүй удаа зохион байгуулсан байна.	Тайлант хугацаанд 28 удаа нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан. Тодруулбал: 2022 оны 03 дугаар сарын 18, 04 сарын 12-ны өдрүүдэд "Бүртгэлийн элч" нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, Арвайхээр сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 6 сургуулийн 2005, 2006 оны 16 нас хүрсэн иргэний үнэмлэх аваагүй сурагчдын судалгааг сургуулийн захиргаатай хамтран гаргаж, мэдээллийн санд тулгалт хийж, мэдээлэл нь зөрчилтэй 25 хүүхдийн зөрчлийг засварлан, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 167 хүүхдийг бүртгэлд хамруулсан. "Улсын бүртгэл-Урьж байна" аяны хүрээнд 19 суманд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан. Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр "Цахим гарын үсгийн тухай хууль"-ийн танилцуулга хийж, тоон гарын үсэг олгох үйл ажиллагаа, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл зэрэг үйлчилгээг газар дээр нь үзүүлж нийт 2800 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлсэн. 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 11 дүгээр сарын 08-ны өдөр тус аймгийн Хархорин суманд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт тус тус оролцон хуулийн этгээдийн бүртгэлийн талаар мэдээ, мэдээллийг хүргэн нотлох баримт нь бүрдсэн 2 хуулийн этгээдийн бүртгэлийг хөтлөн гэрчилгээг гардуулан, 20 орчим иргэдэд үйлчилгээ	100%
-----	--	---	---	--	--	---	------

					<p>авахад шаардлагатай бүрдүүлэх материалыг хэлж, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр бүртгэлээ сурталчилан ажилласан. Хуулийн байгууллагуудын дунд зохион байгуулсан төрийн байгууллагын "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т 2022 оны 03 дугаар сард оролцож эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр мэдээлэл зөвлөгөөг өгч нийт 78 иргэдэд эд хөрөнгийн чиглэлээр зөвлөгөө үзүүлсэн.Түүнчлэн Хархорин суманд 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулсан "Бүртгэлийн элч-82" нээлттэй хаалганы өдөрлөгт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 87 иргэний бүртгэлийг цахим мэдээллийн санд боловсруулж, 113 иргэнд зөвлөгөө өгч ажилласан.</p>	
--	--	--	--	--	--	--

3.1	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	-	Хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон тоо; -Шийдвэрийн мэдээлэл;	-2021 онд 3 хэрэг маргаанд улсын бүртгэлийн байгууллагыг төлөөлөн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон.	-Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, байгууллагын эрх ашгийг бүрэн хамгаалсан байна.	Тайлант хугацаанд аймгийн Захиргааны хэргийн шүүхэд хандсан улсын бүртгэлийн байгууллагад холбогдох 4 иргэний нэхэмжлэлд хяналтын улсын байцаагч С.Анхтуяа, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Г.Одончимэг нар нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож шүүхэд тайлбар гаргаж, шаардлагатай мэдээллээр хангаж, шүүх хуралдаанд төлөөлөн оролцлоо. Үүнд: Б. Батбилэг нь үрчлэлт хүчингүй болгуулах тухай, Ш.Наранхүү нь охин Бумсүрэнгийн үрчлэлт хүчингүй болгуулах Г.Цэрэннадмидийн үрчлэлт хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлд хяналтын улсын байцаагч хэлтсийг төлөөлөн тайлбар мэдүүлэг гарган шүүх хуралдаанд оролцсоноос үрчлэлтийн бүртгэлийг хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэр гарсан ба шийдвэрийг хэрэгжүүлж иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн хэрэгжилтийг хангаж ажилласан. Иргэн Д.Бямбасүхийн нэхэмжлэлтэй улсын бүртгэлийн хэлтэст холбогдох эрхийн улсын бүртгэлийн ү1005000066 дугаартай, Өвөрхангай аймгийн Бүрд сумын 5-р баг, Онгон Мааньт 1 гудамж, 119 тоот хаягт байршилтай, 95мкв талбайтай, хувийн сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагатай маргаанд одоогийн байдлаар урьдчилсан хэлэлцүүлэгт оролцсон байна.	100%
-----	---	---	--	--	--	--	------

Зорилт 4. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.							
4.1	Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	-	-Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-.	-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана	Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллалаа. Улсын бүртгэлийн ерөнхий газарт дэмжлэг хүссэн хүсэлт хүргүүлэн хуулийн этгээдийн улсын бүртгэгч У.Должинсүрэнд ар гэрт нь дэмжлэг болгож 2,000,000 төгрөг, Зүүнбаян-Улаан сумын улсын бүртгэгч Г.Цэрэндоржид 7,500,000 төгрөгийн өртөг бүхий 5 ханатай гэр олгуулсан. Хэлтсийн албан хаагчдын 75 хүүхдэд хүүхдийн баярын өдрийн тохиолдуулан 1,125,000 төгрөгний бэлэг, хэлтсийн 11 ахмад ажилтанд 550,000 төгрөгийн мөнгөн тэтгэмж, алба хаагчдын ажилласан жил, гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн 25 албан хаагчийн шатлал ахиулсан, Төрийн үйлчилгээний 5 алба хаагчдад хэлтсийн даргын 2022.01.03-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар ур чадварын нэмэгдэл олгосон. хэлтэст үр бүртээлтэй, 10-аас жил ажилласан 11 алба хаагчид эзэмших зориулалттайгаар гэр бүлийн хэрэгцээний газар олгуулсан. Бүртгэлийн байгууллагат ажилласан хөдөлмөр, үр бүтээлийг нь үнэлж, төрийн дээд одон медалиар 4 албан хаагч, улсын бүртгэлийн тэргүүний ажилтан 1 албан хаагч, залуучуудын холбооны шагналаар 2 албан хаагч, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шагналаар 2 албан хаагч, хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар 6 албан хаагч, улсын бүртгэлийн ерөнхий газрын жуухаар 3 албан хаагч тус тус шагнагдсан.	45%

						<p>Арвайхээр сумын "Эко" заалтай 2021 оны 11 дүгээр сараас 2022 оны 06 дугаар сар хүртэл 7 хоног бүрийн пүрэв гарагт тоглож байхаар түрээсийн гэрээ байгуулсан. 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд эрүүл мэндийн эрт илрүүлэх үзлэгт 41 алба хаагч хамрагдсан.</p>	
--	--	--	--	--	--	---	--

4.2	“Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2022”-ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	-Сургалтын төлөвлөгөө батлагдсан эсэх; - Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2021 онд алба хаагчдад нийт 14 сургалт зохион байгуулсан.	-Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Албан хаагчдын сургалт-хөгжил сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. УБЕГазраас зохион байгуулсан 24 удаагийн онлайн сургалтанд холбогдох алба хаагчдыг хамруулсан ба 19 сумын улсын бүртгэгч нарын хамруулсан онлайн сургалт 5 зохион байгуулж ажиллалаа. Хэлтсийн хэмжээнд дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: "Угийн бичиг, түүний хэрэглээ" сэдвээр 09 дүгээр сарын 22 өдөр гэр бүл хүүхэд залуучуудын газрын мэргэжилтэн Д.Төвхөнбаяр, "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж" гэсэн сэдвээр 10 дугаар сарын 04-ний өдөр аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтэн П.Оюунтуяа, "Хувь хүний хөгжил, гэр бүлийн харилцаа,хүүхдийн хүмүүжилд бидний оролцоо" сэдвээр 11 дүгээр сарын 09-ний өдөр мэргэжилтэн Н.Гэрэлтуяа, "Хувь хүний хөгжил, төлөвшил" сэдвээр 11 дүгээр сарын 16-ны өдөр аймгийн Гандан пунцоглин хийдийн хамба лам, доктор Я.Ганзаяа, эд хөрөнгийн улсын бүртгэлийн тасгаас "Шинэ бүртгэгч- Шинэ ажлын байр" сэдвээр 09 дүгээр сарын 08-ны өдөр онлайн болон танхимын сургалт, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн цагдаагийн газрын эдийн засгийн ахлах мөрдөгч ахмад Н.Ул-Олдох улсын бүртгэгч нарт" Итгэвэл шалгая аяны хүрээнд "авлига-гэмт хэрэг-төрийн захиргааны албан хаагчийн ес зүй" сэдвээр, Аймгийн тагнуулын газрын мэргэжилтэн Ч.Ууганбаяр алба хаагчдад "Төрийн нууц Албаны нууцын тухай хууль тогтоомж, мэдээллийн сангийн аюулгүй	100%
-----	---	---	---	---	--	---	------

						байдал" зэрэг сэдвүүдээр тус тус сургалтуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 250 албан хаагчийг хамруулсан.	
--	--	--	--	--	--	---	--